

“Ахмад-залуу багш нарын залгамж холбоо”
Сургалтын арга зүйн өдрүүдийн үйл ажиллагааний тайлан

ШУТИС. Барилга Архитектурын сургуульд сургалтын алба, чанарын баг, салбар, тэнхимийн эрхлэгч нар хамтран зохион байгуулсан “Ахмад-залуу багш нарын залгамж холбоо” Сургалтын арга зүйн өдрүүд 2022.03.23 – 2022.04.08-ны хооронд амжилттай явагдаж дууслаа.

№	Салбар, тэнхим	Нийт багш нар	Хуваарийн дагуу нээлттэй хичээл хийх ёстой багш нарын		Нээлттэй хичээл хийсэн багш нарын	
			тоо	Хувь	Тоо	Хувь
1	ИЗЗТ	18	18	100	17	94.4
2	Архитектур	20	10	50	9	90.0
3	ХБОИС	13	3	23.1	2	66.7
4	ИБС	15	4	26.7	4	100
5	БИС	33	8	24.2	7	87.5
Нийт		99	43	44.8	31	90.22

Энэхүү арга хэмжээнд багш нар бие биенийхээ хичээлд хуваарийн дагуу суун, хичээлийн үйл явцад ажиглалт ба хяналтыг хийсэн. Нийт сургуулийн хэмжээнд 99 багшаас 43 багш буюу 44.8% нээлттэй хичээлийг төлөвлөсөн боловч 31 багш буюу **31.3%** нээлттэй хичээлийг төлөвлөгөөний дагуу хийсэн. Төлөвлөгөөний дагуу хийсэн ажлыг авч үзвэл 72.1%-ийн биелэлтэйгээр амжилттай явагдаж дууслаа. Энэхүү “Ахмад-залуу багш нарын залгамж холбоо”-г “Багшийн дэвтэр”-ийн 70-р хуудасны дагуух хөтлөлтөнд дүн шинжилгээ хийхэд сургалтын арга зүйн өдрүүдийг бие биенээсээ суралцсан, туршлага солилцсон, алдаа оноогоо ярилцаж хэлэлцсэн, ахмад багш нар заавар, зөвөлгөөгөө харамгүй хайрласан харилцан үр ашигтай, ахиц дэвшилттэй ажил боллоо гэж дүгнэж байна. Салбар, тэнхимийн эрхлэгч нар тухайн асуудлуудыг анхаарлаа авч ажиллана гэдэгт итгэж байна.

Тайлагнасан:
2022.05.18-ны өдөр

ШУТИС-БАС-ийн дэд захирал



М.Сугар

Ахмад-Залуу багш нарын залгамж холбоо-Сургалтын арга зүйн өдрүүд

БАС-ийн сургалтын үйл явцыг сайжруулж, ахмад-залуу багш нарын залгамж холбоог бэхжүүлэх зорилгоор **“Ахмад-Залуу багш нарын залгамж холбоо-Сургалтын арга зүйн өдрүүд”**-ийг сургалтын алба, чанарын багтай хамтран 2022.03.23 өдрөөс 2022.04.08 өдрүүдэд зохион байгуулах гэж байна.

Энэхүү арга хэмжээ нь сургалтын чанарыг сайжруулах, хичээлийн агуулга, заах аргачлалд зөвлөгөө өгөх, мөн туршлага солилцох, шинэлэг санаа, шинэлэг сургалтын аргачлалыг сургалтанд нэвтрүүлэх, залуу багш нарт зөвлөмж өгч, цаашид сургалт явуулахад дэмжлэг туслалцаа үзүүлэх ач холбогдолтой болно.

Иймд салбар тус бүрээс сонгогдсон багш нарын хичээлд салбарын профессор багш нар сууж, зөвлөгөө өгч, санал бодлоо солилцсон байна.

2022.04.13 өдөр хичээлд суусан салбарын профессор багш тайлан ирүүлнэ. Тайланг *Багшийн Дэвтэр*-ийн 70-р хуудасны дагуу хөтөлж ирүүлэх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ, анхаарах зүйлийг дурдсан байх, шинэ санаа, шинэлэг аргыг хэрхэн нэвтрүүлэхийг бичих гэх мэт байж болно.

Та бүхний ажилд амжилт хүсье

БАС-ийн Сургалтын алба, Чанарын баг, Салбарын Эрхлэгч

2022-03-21

Батлав: Тэнхимийн эрхлэгч



Ч. Мягмаржав

2021-2022 оны хичээлийн жилийн хаврын улиралд Инженерийн зурагзүйн тэнхимийн багш нарын хичээлд суух хуваарь

№	Хичээлийн нэр	Хичээл заах багш	Хичээлд суух багш
1	A.EDA201 Архитектурын зураглал	Ч. Оюунжаргал	Б. Жигжид
2	A.EDB202 Барилгын зурагзүй	С. Золжаргал	Н. Чулуунбаатар
3	S.ED202 Машин үйлдвэрлэлийн зурагзүй	О.Ганжаргал	Ц. Отгонбаяр
4	S.ED202 Машин үйлдвэрлэлийн зурагзүй	Л. Мөнхтуяа	Э. Сувд
5	A.EDB204 Барилгын зурагзүй	Н. Чулуунбаатар	Ч. Оюунжаргал
6	A.EDB204 Барилгын зурагзүй	Ш. Ойдов	Т. Болдбаатар
7	A.AR 328 Архитектурын гурван хэмжээст загварчлал	Х. Дамчаасүрэн	Б. Батсүрэн
8	S.ED201 Техникийн зурагзүй	Ц. Амарсанаа	Э. Оюунзаяа
9	S.ED201 Техникийн зурагзүй	Б. Батсүрэн	Ч. Мягмаржав
10	S.ED201 Техникийн зурагзүй	Ч. Мягмаржав	Ж. Төмөртоого
11	S.ED201 Техникийн зурагзүй	Э. Оюунзаяа	Л. Мөнхтуяа
12	S.EDM202 Техникийн зурагзүй	Н. Доржбалдан	Ц. Амарсанаа
13	S.EDM202 Техникийн зурагзүй	Ж. Төмөртоого	У. Лхагвадорж
14	S.ED203 Инженерийн зурагзүй	Т. Болдбаатар	Ш. Ойдов
15	A.EDA 101 Дүрслэх геометр	Б. Дониддулам	Н. Доржбалдан
16	A.EDA 101 Дүрслэх геометр	У. Лхагвадорж	О. Ганжаргал
17	S.ED 101 Дүрслэх геометр	Э. Сувд	Х. Дамчаасүрэн
18	A.AR109 Уран зураг	Ц. Отгонбаяр	Энхтүвшин

Тайлбар:

- 2022 оны 03-р сарын 29-өөс 04-р сарын 08-ны хооронд хичээлд сууна.
- Хичээлд суух багш нар багшийн заах арга, хичээлийн чанарт хяналт тавьж зөвлөгөө өгөхөөс гадна хичээлийн файл бүрдэлт, агуулга, стандарт, календарчилсан төлөвлөгөөний хэрэгжилтэнд хяналт тавьж, багшийн хичээлд суусан тэмдэглэлийг Д. Төгсжаргалд хураалгана.
- Хичээлд суух тоо болон цагийг дурын сонголтоор шийдэх эрх хичээлд суух багшид байна.
- Өөрийн сайн дураар нээлттэй хичээл хийж, туршлага солилцох нь тэнхимийн бүх багш нарт нээлттэй.